



# СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:

Газрын дарга: С.Энхзаяа  
Утас: 261663

Аудитын менежер: Л.Одгэрэл  
Утас: 260512

Ахлах аудитор Б.Болормаа  
Шинжээч О.Дашжамц

Монгол Улсын Үндэсний Аудитын  
Газар  
Улаанбаатар-46  
Бага тойруу 6  
Засгийн газрын IY байр  
Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

### АГУУЛГА

---

Оршил  
Санхүүгийн дотоод хяналт  
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд  
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт  
Аудитын санал дүгнэлт

**Хавсралт 1:** Аудитын гэрчилгээ

**Хавсралт 2:** Менежментийн захидал

**Хавсралт 3:** Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн  
тайлан

**Хавсралт 4:** Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн  
тайлан

2014 оны 4 дүгээр сар

## Оршил

Сонгуулийн ерөнхий хорооны 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын тайланд Сонгуулийн ерөнхий хорооны харьяа Мэдээллийн технологийн төвийн 2013 оны санхүүгийн үйл ажиллагааг хамруулсан ба үйлчлүүлэгчийн санхүүгийн дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, объект дээрх үе шат, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитаар Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2013 оны нэгтгэсэн санхүүгийн байдал, үр дүн, мөнгөн гүйлгээ болон цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан, тодруулгыг баталгаажуулан, санал дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар гаргалаа.

### Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Аудитын явцад Сонгуулийн ерөнхий хороо санхүүгийн дотоод хяналтыг үнэлэхэд үйл ажиллагаандаа Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасны дагуу Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөн ажилласан байна.

Ийнхүү уг бодлогын баримт бичгийг бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдлөг болгосноор санхүүгийн дотоод хяналтын иж бүрэн тогтолцоо бий болох юм.

### **Аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд**

Сонгуулийн ерөнхий хорооны 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг нэгтгэн хөндөгдсөн дараах гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

Нэг. Зохион байгуулсан сонгуулийн зардлын талаар

1.1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны сонгууль:

Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгууль зохион байгуулах зардал 17,209.5 сая төгрөгөөр батлагдсан бөгөөд УИХ-ын 2013 оны 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн зардлын дээд хэмжээг 15846,8 сая төгрөг тогтоож, Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 12,560.5 сая төгрөг болгон буруулан баталсан байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуульд 11,136.2 сая төгрөг зарцуулж, 4,710.6 сая төгрөгийг хэмнэсэн байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуулийн аймаг, нийслэлийн сонгуулийн хороодын бичиг хэрэг, шуудан холбоо, хэсгийн хорооны ажиллах болон санал авах байр бэлтгэх, унаа, албан томилолт, сонгуулийн хорооны гишүүн, мэдээллийн технологийн багийн гишүүн, хэсгийн хорооны даамлын сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны мөнгө, сургалт, сурталчилгаа хийх, сонгогчдын нэрийн жагсаалтын маягт хэвлүүлэх, санал тоолох, дүн гаргах машин, дагалдах хэрэгсэл, саналын хуудсыг салбар, хэсгийн хороонд хүргэх тээврийн зардал, сонгуулийн автоматжуулсан системийг хэрэглэхтэй холбоотой зардлуудад нийт 6,839.3 сая төгрөгийг зарцуулжээ.

#### 1.2. УИХ-ын 26 дугаар тойргийн дахин санал хураалт:

УИХ-ын 2013 оны 27 дугаар тогтоолоор УИХ-ын 26 дугаар тойргийн дахин санал хураалтын зардлын дээд хэмжээг 397.5 сая төгрөгөөр баталсан бөгөөд үүнийг СЕХ-ны төсөвт батлагдсан сонгуулийн зардлаас гаргахаар шийдвэрлэсэн байна.

Тус тойргийн хороо сонгуулийн гарч болзошгүй зардалд болон саналын хуудас хэвлүүлэх, сонгуулийн автоматжуулах системийг хэрэглэх, сонгуулийн хууль тогтоомж сурталчлах, бүртгэлийн байгууллагын зардалд нийт 297.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

#### 1.3. Говь-Алтай аймгийн ИТХ-ын дахин сонгууль:

Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасны дагуу сонгуулийн зардалд 32.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Сонгуулийн саналын хуудас болон сонгуулийн автоматжуулах тоног төхөөрөмжийг нисдэг тэргээр аймгуудын сонгуулийн хороонд хүргэх болон татан авахад 354.0 сая төгрөг зарцуулсан боловч холбогдох анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна. Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 19.1.3-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

#### **Хоёр: Төсвийн хөрөнгийн зарцуулалтын талаар**

Сонгуулийн Ерөнхий Хорооны зардал Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуулиар 18,034.8 сая төгрөг, 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар 13,005,9 сая төгрөгөөр батлагдсан. Үүнээс Сонгуулийн Ерөнхий Хорооны үйл ажиллагааны зардалд 380.0 сая төгрөг, сонгуулийн зардалд 12,180.6 сая төгрөг, хөрөнгө

оруулалтын зардалд 133.8 сая төгрөг, СЕХ-ны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн зардалд 311.5 сая төгрөг тус тус батлагдсан байна.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг хэрэгжүүлэх холбогдох заавар журмын төслийг боловсруулж батлуулах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуулийг зохион байгуулж явуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад батлагдсан төсвийн хөрөнгийг зарцуулсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны урсгал зардал 11,993.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 191.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлж, жилийн эцсийн байдлаар зарим зардал хэмнэлттэй гарсан байна. Тухайлбал, цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 28.0 сая, тээвэр шатахуун 320.8 сая, байрны түрээсийн зардал 123.0 сая, сонгуулийн зардал 712.9 сая төгрөг зэрэг хэмнэлттэй гарсан байна.

Энэ нь хэвлэл мэдээллийн төлөөлөгч, нягтлан бодогч зэрэг зарим орон тоог хагас орон тоогоор ажиллуулсан, мөн зарим ажилтнуудын зэрэг дэвийн нэмэгдлийг олгох хугацаа болоогүй байснаас цалин, НДШ-ийн зардал хэмнэгдсэн, мөн сонгуулийн автоматжуулсан системийн тоног төхөөрөмжийг хадгалах, хамгаалах зорилгоор байгуулсан агуулахын байр түрээслэх гэрээ цуцлагдаж, Засгийн газрын 11 дүгээр байрны 2, 13 дугаар давхарын заалыг агуулахын зориулалтаар ашиглах болсон тул байрны түрээсийн зардал хэмнэгдсэн байна.

МУ-ын 2013 оны төсвийн тухай хуулиар Сонгуулийн ерөнхий хороонд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж худалдан авахад 133.8 сая төгрөг батлагдсанаас сонгуулийн автоматжуулах тоног төхөөрөмжийг тээвэрлэх зориулалттай бага оврын ачааны автомашиныг 37.9 сая, мөн уг тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл зөөвөрлөх, засвар үйлчилгээ үзүүлэх зориулалтын микроавтобусыг 42.2 сая төгрөг, нийт 80.1 сая төгрөгийн автомашиныг худалдан авахдаа Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 болон Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.8-д заасан заалтыг мөрдөөгүй байна.

### **Гурав. Санхүүгийн үйл ажиллагааны талаар**

Сонгуулийн ерөнхий хорооны нягтлан бодогч нь тухайн ажлын байранд бүтэн сууж ажилладаггүй атлаа уг орон тоон дээр тогтмол ажилладаг нэртэй байгаа нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3.4-т “Хороо үйл ажиллагаагаа бие дааж, хараат бус байдлаар явуулна” гэсэн заалтай нийцэхгүй байна.

### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Сонгуулийн ерөнхий хорооны 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2 зөвлөмж өгснийг 100 хувь биелүүлж ажилласан байна.

### **Аудитын санал дүгнэлт**

Бид Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2013 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах аудитыг Аудитын Олон улсын стандартын дагуу, МУ-ын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эдгээр стандартад зааснаар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор касс, харилцахын болон бусад анхан шатны баримтыг дэлгэрэнгүй, хураангуй бүртгэл, тайлангийн зохих үзүүлэлттэй тулган шалгав.

Бидний дүгнэлтээр Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар бэлтгэсэн санхүүгийн тайлангууд нь бүгд материаллаг зүйлсийн хувьд Монгол Улсад мөрдөж байгаа стандарт, холбогдох журам, зааврын дагуу үнэн зөвөөр илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ  
ХОРООНЫ ДАРГА Ч.СОДНОМЦЭРЭН  
ТАНАА

2014.04.25 № 681  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Сонгуулийн ерөнхий хорооны удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсвийн 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлэгдсэн байна.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР  А.ЗАНГАД

# СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГЫН ТӨСВИЙН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

## Менежментийн захидал

### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

#### Асуудал 1

Зардал

#### Асуудал 2

Төсвийн хөрөнгийн зарцуулалт

#### Асуудал 3

Санхүүгийн үйл ажиллагаа

## Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг хэрхэн сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандартын дагуу хийгддэг Үндэсний аудитын газрын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан юм.

Энэ нь Сонгуулийн ерөнхий хорооны хэрэгжүүлдэг нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргаж өгсөн бөгөөд таны зүгээс зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх талаар анхаарал тавина гэдэгт найдаж байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Сонгуулийн ерөнхий хорооны санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.



Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав. Үүнд:

<b>Асуудал 1 Зардал</b>	<b>Тэргүүлэх ач холбогдол №1</b>
-------------------------	----------------------------------

### **ҮАГ-ын ажиглалт**

Сонгуулийн саналын хуудас болон сонгуулийн автоматжуулах тоног төхөөрөмжийг нисдэг тэргээр аймгийн сонгуулийн хороонд хүргэх болон татан авахад нийт 354.0 сая төгрөг зарцуулсан боловч холбогдох анхан шатны баримтын бүрдүүлэлт дутуу байна.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 19.1.3-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах” гэж заасныг мөрдөөгүй байна.

### **Эрсдэлүүд**

Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийснээс зарцуулалт буруу тайлагнагдах, бэлэн мөнгөний зарцуулалтын хяналт суларч ашиглал үүсэх.

### **Зөвлөмж**

“Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 19 дүгээр зүйлийн 19.1.3-т “нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад материалыг шаардан гаргуулах” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

### **Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

**Ажиглалт**

Монгол Улсын 2013 оны Төсвийн тухай хуулиар Сонгуулийн ерөнхий хорооны даргын төсөвт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж худалдан авахад 133.8 сая төгрөг батлагдсанаас сонгуулийн автоматжуулах тоног төхөөрөмжийг тээвэрлэх зориулалттай бага оврын ачааны автомашиныг 37.9 сая, мөн уг тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл зөөвөрлөх, засвар үйлчилгээ үзүүлэх зориулалтын микроавтобусыг 42.2 сая төгрөг, нийт 80.1 сая төгрөгийн автомашиныг худалдан авахдаа Төрийн өмчийн хорооноос зөвшөөрөл аваагүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 болон Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.8-д заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Эрсдэлүүд**

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө худалдан авснаас үндсэн хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт суларч, үргүй зардал гарах

**Зөвлөмж**

Үндсэн хөрөнгийг худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3-д “Төрийн өмчит хуулийн этгээд үл хөдлөх хөрөнгийг захиалгын үндсэн дээр зөвхөн Төрийн өмчийн хорооны шийдвэрээр олж авна”, мөн Төрийн өмчийн хорооны 2012 оны 44 тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.8-д “Эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах тухай Төрийн өмчийн хорооны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг тухайн хуулийн этгээдийн дарга хариуцан зохион байгуулж, биелэлтийг шийдвэрт заасан хугацаанд холбогдох материалын хамт Төрийн өмчийн хороонд ирүүлэх үүрэг хүлээнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

**ҮАГ-ын ажиглалт**

Сонгуулийн ерөнхий хорооны санхүүгийн үйл ажиллагааг хариуцсан орон тооны ажилтан хавсран ажиллаж байгаа нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3.4-т Хороо үйл ажиллагаагаа бие дааж, хараат бус байдлаар явуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Эрсдэлүүд**

Санхүүгийн үйл ажиллагааг хариуцсан хүнгүйгээс нягтлан бодох бүртгэлд тавих хяналт хангалтгүй байх

**Зөвлөмж**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3.4-т “Хороо үйл ажиллагаагаа бие дааж, хараат бус байдлаар явуулна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2014 оны 7 дугаар сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

**Үйлчлүүлэгчийн хариу**

Зөвлөмжийг хүлээн зөвшөөрч байна. Цаашид хэрэгжүүлж ажиллах болно.

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
Кассад байгаа бэлэн мөнгө	0	0
Жижиг мөнгөн сан	0.00	0.00
Төсөвт байгууллагын харилцахын үлдэгдэл	0.00	0.00
Замд яваа мөнгөн хөрөнгө	0	0
<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	0	0
<b>АВЛАГА</b>	<b>5,837,900.00</b>	<b>0.00</b>
Бусад авлага	5,837,900.00	0.00
<b>УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР</b>	0.00	<b>0.00</b>
Урьдчилгаа тооцоо	0.00	0.00
Урьдчилж гарсан зардал		0.00
<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>108,951,143.72</b>	<b>154,613,333.22</b>
Бичиг хэргийн материал	3,181,708.00	9,976,050.00
Аж ахуйн материал	101,627,888.72	132,537,217.22
Бусад	4,141,547.00	12,100,066.00
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>114,789,043.72</b>	<b>154,613,333.22</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>		
<b>БУСАД ХӨРӨНГӨ</b>		
<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>12,721,062,876.42</b>	<b>9,459,259,719.76</b>
<b>Биет хөрөнгө</b>	<b>10,392,226,601.22</b>	<b>7,650,641,120.56</b>
Авто тээврийн хэрэгсэл	0.00	80,100,000.00
Хуримтлагдсан элэгдэл	0.00	-6,675,000.00
Машин, тоног төхөөрөмж /компьютер/	11,775,569,305.88	11,870,833,815.88
Хуримтлагдсан элэгдэл	-1,529,019,835.39	-4,471,461,145.23
Тавилга, аж ахуйн эд хогшил	200,226,150.00	251,196,113.00
Хуримтлагдсан элэгдэл	-54,549,019.27	-73,352,663.09
<b>Биет бус хөрөнгө</b>	<b>2,328,836,275.20</b>	<b>1,808,618,599.20</b>
Программ хангамж	2,589,216,579.95	2,589,216,579.95
Хуримтлагдсан элэгдэл	-260,380,304.75	-780,597,980.75
Бусад	0	0
Хуримтлагдсан элэгдэл	0	0
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,721,062,876.42</b>	<b>9,459,259,719.76</b>

<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>12,835,851,920.14</b>	<b>9,613,873,052.98</b>
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0	0
Өглөг	0	0
Урьдчилж орсон орлого	0.00	0.00
Төсөвт байгууллага	0.00	0.00
Бусад урьдчилж орсон орлого		
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>		
<b>УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	0	0
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧ</b>	0	0
<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>12,835,851,920.14</b>	<b>9,613,873,052.98</b>
ЗГ-ын оруулсан капитал	14,410,826,088.57	14,410,826,088.57
Хуримтлагдсан үр дүн	-1,576,911,258.19	-4,798,890,125.35
Өмнөх үеийн үр дүн	-15,432,472.98	-1,576,911,258.19
Тайлант үеийн үр дүн	-1,561,478,785.21	-3,221,978,867.16
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,937,089.76	1,937,089.76
Бодлогын өөрчлөлтийн алдааны залруулга	0.00	0.00
<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,835,851,920.14</b>	<b>9,613,873,052.98</b>
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>12,835,851,920.14</b>	<b>9,613,873,052.98</b>

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН - ГҮЙЦЭТГЭЛ
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</b>		
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>24,711,226,433.22</b>	<b>12,322,673,107.00</b>
<b>Улсын төсвөөс</b>	<b>24,711,226,433.22</b>	<b>12,322,673,107.00</b>
Урсгал	21,575,101,985.82	12,184,138,132.00
ЗГ-ын нөөц хөрөнгө	74,652,000.00	0.00
Төсөл арга хэмжээ	205,192,200.00	0.00
Орон нутгийн төсвөөс /Саналын хуудас/	1,410,293,299.60	0.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	322,850.32	48,400.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,433,266,255.00	9,474,900.00
Урьд оны төсвийн хэмнэлтийн орлого	12,397,842.48	0.00
Хөрөнгө оруулалтын санхүүжилт		129,011,675.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>24,711,226,433.22</b>	<b>12,322,673,107.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		
<b>АЖИЛЛАГЧИДАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	<b>270,080,798.23</b>	<b>355,962,886.95</b>
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	243,205,705.14	320,851,186.06
Цалин	229,627,905.14	304,131,820.12
Унаа хоол	13,577,800.00	16,719,365.94
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>26,875,093.09</b>	<b>35,111,700.89</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	21,989,067.57	28,727,779.92
Тэтгэврийн даатгалын шимтгэл-7%	17,117,060.62	22,343,723.41
Тэтгэмжийн даатгалын шимтгэл-0.8%	1,220,658.33	2,553,568.38
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл-1%	2,430,690.28	3,192,096.03
Ажилгүйдлын даатгалын шимтгэл-0.2%	1,220,658.34	638,392.10
Эрүүл мэндийн даатгалын хураамж-2%	4,886,025.52	6,383,920.97
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>26,002,624,420.20</b>	<b>15,185,437,928.78</b>
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>25,984,213,446.20</b>	<b>15,179,520,548.78</b>
Бичиг хэргийн материал	30,903,583.00	23,122,547.00
Тээвэр, шатахууны зардал	27,217,778.00	29,138,880.00
Шуудан холбооны зардал	17,144,581.77	16,334,562.44
Дотоод томилолтын зардал	6,002,052.04	12,860,735.00
Гадаад томилолтын зардал	35,082,733.00	50,547,495.00
Ном, хэвлэлийн зардал	18,924,300.00	6,923,276.00
Сургалт семинар зохион байгуулах зардал	4,875,800.00	0.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	1,358,293,024.00	129,074,004.50
Төлбөр, хураамж, жижиг татварууд зардал	4,216,269.00	2,870,444.00

Байрны түрээсийн зардал	34,534,506.00	44,123,070.00
Элэгдлийн зардал	1,748,388,682.82	3,484,886,471.23
Сонгуулийн зардал	17,118,098,266.74	11,181,298,733.60
Ой тэмдэглэх арга хэмжээний зардал	28,640,934.00	0.00
Урьд оны төсвийн хэмнэлээс зацуулсан	1,237,020.00	0.00
УИХ-д суудалтай намд төсвөөс олгох дэмжлэг	3,344,587,696.29	0.00
Олон улсын байгууллагын гишүүний татвар	1,300,000.00	1,405,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	546,070,081.54	5,837,869.00
		191,097,461.01
ЗГ-ын нөөц хөрөнгө	74,652,000.00	0.00
Төсөл арга хэмжээ	1,584,044,138.00	0.00
<b>Ажил олгогчоос өрх гэрт олгох тэтгэмж</b>	<b>18,410,974.00</b>	<b>5,917,380.00</b>
Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,200,000.00	2,250,000.00
Шагнал урамшуулал	4,939,500.00	3,667,380.00
Нэг удаагийн тэтгэмж	11,271,474.00	0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>26,272,705,218.43</b>	<b>15,541,400,815.73</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-1,561,478,785.21</b>	<b>-3,218,727,708.73</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО</b>		
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)	0	0
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	0.00	0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ</b>	<b>0</b>	<b>0</b>
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)	0	0
Хөрөнгө худалдсаны гарз	0	3,251,158.43
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0</b>	<b>3,251,158.43</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН</b>	<b>-1,561,478,785.21</b>	<b>-3,221,978,867.16</b>

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>21,854,946,185.82</b>	<b>12,184,138,132.00</b>
Улсын төсвөөс	21,854,946,185.82	12,184,138,132.00
Урсгал	21,575,101,985.82	12,184,138,132.00
ЗГ-ын нөөц хөрөнгө	74,652,000.00	0.00
Төсөл арга хэмжээ	205,192,200.00	0.00
Орон нутгийн төсвөөс /Саналын хуудас/	1,410,293,299.60	0.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	322,850.32	5,886,300.00
Урьд оны төсвийн хэмнэлт	12,397,842.48	0.00
Урьд оны хөрөнгө оруулалтын үлдэгдэл	24,000,000,000.00	0.00
		129,011,675.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>47,277,960,178.22</b>	<b>12,319,036,107.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</b>		<b>12,190,024,432.00</b>
<b>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</b>	<b>270,080,798.23</b>	<b>355,962,886.95</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>243,205,705.14</b>	<b>320,851,186.06</b>
Цалин	229,627,905.14	304,131,820.12
Цалингийн тусгай нэмэгдлүүд	13,577,800.00	16,719,365.94
<b>Нийгмийн хамгааллын шимтгэл</b>	<b>26,875,093.09</b>	<b>35,111,700.89</b>
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	21,989,067.57	28,727,779.92
Тэтгэврийн даатгалын шимтгэл-7%	17,117,060.62	22,343,723.41
Тэтгэмжийн даатгалын шимтгэл-0.8%	1,220,658.33	2,553,568.38
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл-1%	2,430,690.28	3,192,096.03
Ажилгүйдлын даатгалын шимтгэл-0.2%	1,220,658.34	638,392.10
Эрүүл мэндийн даатгалын хураамж-2%	4,886,025.52	6,383,920.97
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>19,694,998,566.09</b>	<b>11,834,061,545.05</b>
<b>Бусад бараа үйлчилгээний зардал</b>	<b>19,676,587,592.09</b>	<b>11,828,144,165.05</b>
Бичиг хэргийн зардал	7,887,071.00	4,104,075.00
Тээвэр, шатахууны зардал	27,217,778.00	29,138,880.00
Шуудан холбооны зардал	17,144,581.77	16,334,562.44
Дотоод томилолтын зардал	6,002,052.04	12,860,735.00
Гадаад томилолтын зардал	34,805,387.00	50,860,984.00
Ном, хэвлэлийн зардал	1,469,750.00	1,048,400.00
Сургалт семинарын зардал	4,875,800.00	0.00
Жижиг эд хогшил худалдан авах зардал	97,282,784.00	0.00
Төлбөр, хураамж, жижиг татварууд	5,431,967.00	3,712,044.00
Байрны түрээсийн зардал	34,534,506.00	44,123,070.00
Сонгуулийн зардал	17,162,637,321.74	11,467,621,084.60
Ой тэмдэглэх арга хэмжээний зардал	31,170,400.00	0.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	546,070,081.54	196,935,330.01
Урьд оны төсвийн хэмнэлтээс зарцуулсан	12,208,898.00	0.00



Олон улсын байгууллагын гишүүний татвар	1,300,000.00	1,405,000.00
ЗГ-ын нөөц хөрөнгө	74,652,000.00	0.00
Төсөл арга хэмжээ	1,611,897,214.00	0.00
<b>Ажил олгогчоос өрх гэрт олгох тэтгэмж</b>	<b>18,410,974.00</b>	<b>5,917,380.00</b>
Нэг удаагийн тэтгэмж	11,271,474.00	0.00
Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,200,000.00	2,250,000.00
Шагнал урамшуулал	4,939,500.00	3,667,380.00
<b>Төрийн бус байгууллагад олгох хандив, тусламж</b>	<b>3,344,587,696.29</b>	<b>0.00</b>
УИХ-д суудалтай намд төсвөөс олгох дэмжлэг	3,344,587,696.29	0.00
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)</b>	<b>23,309,667,060.61</b>	<b>12,190,024,432.00</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)</b>	<b>23,968,293,117.61</b>	<b>129,011,675.00</b>
<b>Хөрөнгийн орлого</b>	0.00	0.00
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0	0
Бусад хөрөнгө борлуулсны орлого	0	0
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)</b>	<b>0</b>	<b>0</b>
Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал		129,011,675.00
Урьд оны хөрөнгө оруулалтын үлдэгдэл	22,912,572,224.70	0.00
УОХО-лтын буцаалт	1,087,427,775.30	-
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)</b>	<b>24,000,000,000.00</b>	<b>129,011,675.00</b>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(VI)=(IV)-(V)</b>	<b>-24,000,000,000.00</b>	<b>-129,011,675.00</b>
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		<b>0.00</b>
Авсан зээл		
Төлсөн зээл		
<b>САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН</b>	<b>-31,706,882.39</b>	<b>0.00</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)</b>	<b>-31,706,882.39</b>	<b>0.00</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	31,706,882.39	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ДАХИН ҮНЭЛГЭЭ	ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО
2011 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	143,029,852.62	1,937,089.76	-15,432,472.98	129,534,469.40
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Тайлант үеийн үр дүн	14,267,796,235.95	0.00	-1,561,478,785.21	12,706,317,450.74
<b>2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	<b>14,410,826,088.57</b>	<b>1,937,089.76</b>	<b>-1,576,911,258.19</b>	<b>12,835,851,920.14</b>
Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт				
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,221,978,867.16	-3,221,978,867.16
<b>2013 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>14,410,826,088.57</b>	<b>1,937,089.76</b>	<b>-4,798,890,125.35</b>	<b>9,613,873,052.98</b>

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН ТАЙЛАН

2013 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ	ХУВЬ
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>12,872,097,500.00</b>	<b>11,993,089,101.99</b>	<b>879,008,398.01</b>	<b>93.2</b>
<b>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>12,872,097,500.00</b>	<b>11,993,089,101.99</b>	<b>879,008,398.01</b>	<b>93.2</b>
<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>12,872,097,500.00</b>	<b>11,993,089,101.99</b>	<b>879,008,398.01</b>	<b>93.2</b>
Бараа, үйлчилгээний зардал	12,863,692,500.00	11,985,766,721.99	877,925,778.01	0.0
<b>Ажиллагчидтай холбогдсон зардал</b>	<b>388,182,600.00</b>	<b>355,962,886.95</b>	<b>32,219,713.05</b>	91.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,714,100.00	320,851,186.06	28,862,913.94	91.7
Үндсэн цалин	332,480,100.00	304,131,820.12	28,348,279.88	91.5
Унаа хоолны хөнгөлөлт	17,234,000.00	16,719,365.94	514,634.06	97.0
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	38,468,500.00	35,111,700.89	3,356,799.11	91.3
Тэтгэврийн даатгал /7%/	24,480,000.00	22,343,723.41	2,136,276.59	91.3
Тэтгэмжийн даатгал /0,8%/	2,797,400.00	2,553,568.38	243,831.62	91.3
ҮОМШ өвчний даатгал /1%/	3,497,200.00	3,192,096.03	305,103.97	91.3
Ажилгүйдлийн даатгал /0.2%/	699,600.00	638,392.10	61,207.90	91.3
Байгууллага төлөх ЭМД-ийн хураамж /2%/	6,994,300.00	6,383,920.97	610,379.03	91.3
<b>Бараа, үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,475,509,900.00</b>	<b>11,629,803,835.04</b>	<b>845,706,064.96</b>	<b>93.2</b>
Бичиг хэрэг	4,109,900.00	4,104,075.00	5,825.00	99.9
Тээвэр шатахуун	32,521,500.00	29,138,880.00	3,382,620.00	89.6
Шуудан холбоо	18,926,500.00	16,334,562.44	2,591,937.56	86.3
Дотоод томиллолт	15,125,000.00	12,860,735.00	2,264,265.00	85.0
Гадаад томиллолт /арга хэмжээ/	51,575,000.00	50,860,984.00	714,016.00	98.6
Ном, хэвлэл авах	1,500,000.00	1,048,400.00	451,600.00	69.9
Төлбөр хураамж болон бусад зардал	4,000,000.00	3,712,044.00	287,956.00	92.8
Байрны түрээсийн зардал	167,131,200.00	44,123,070.00	123,008,130.00	26.4
Сонгуулийн зардал	12,180,620,800.00	11,467,621,084.60	712,999,715.40	94.1
<b>Татаас ба урсгал шилжүүлэг</b>	<b>8,405,000.00</b>	<b>7,322,380.00</b>	<b>1,082,620.00</b>	<b>87.1</b>
Өрх гэрт олгох шилжүүлэг	7,000,000.00	5,917,380.00	1,082,620.00	84.5
Нэг удаагийн буцалтгүй тусламж	2,500,000.00	2,250,000.00	250,000.00	90.0
Шагнал урамшуулал	4,500,000.00	3,667,380.00	832,620.00	81.5
Гадаад шилжүүлэг	1,405,000.00	1,405,000.00	0.00	100.0
ОУ-ын гишүүний татвар	1,405,000.00	1,405,000.00	0.00	100.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>12,872,097,500.00</b>	<b>11,993,089,101.99</b>	<b>879,008,398.01</b>	
Төсвөөс санхүүжих	12,872,097,500.0	11,993,089,101.99		
Мөнгөн хөрөнгийн эхний үйлдэгдэл		0.00		0
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00		0
<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>2</b>	<b>2</b>		

АЖИЛЛАГСАД БҮГД	26	26		
Удирдах ажилтан	4	4		
Гүйцэтгэх ажилтан	22	22		